нийлбэр: 520.3 мг/дм<sup>3</sup>

Ерөнхий хатуулаг 7.60 мг-экв/дм<sup>3</sup>

pH: 7.32

Исэлдэх чанар: 1.28 мг/дм<sup>3</sup>

Физик шинж чанар

Тунгалаг: >30 см

Үнэр: үгүй

Өнгө: үгүй

Амт: \*\*\*

Анион катионуудын

нийлбэр: 666.7 мг/дм<sup>3</sup>

ЕС: 908 μS/cm

TDS: 504 ppm

Тунадас: үгүй

Булингаршил: 0.0 NTU

HCO<sub>3</sub> 53 SO<sub>4</sub> 2 37 Cl 7

Усны найрлагын томъёо: M<sub>0.7</sub>

Ca<sup>2+</sup> 65 Mg<sup>2+</sup> 19 Na<sup>+</sup>+K<sup>+</sup> 16


Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуу ус байна.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Хийсэн: Химич, ЭШДА: Магистр (M.Sc)  /Ц.Эрдэнэцэг/

Шинжилгээг

Хянасан: УШ Лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D)  /Б.Одсүрэн/



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН  
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

## Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2021 оны 08 сарын 04 өдөр

Шинжилгээ хийсэн: 2021 оны 08 сарын 06 өдөр

Сорьц авсан газрын нэр: Төв аймаг, Сэргэлэн сум, Баруун Уртын алтны уурхай  
Ундны усны цооног

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "ЭВЭЖ" ХХК

Солбицол:

X=

Y=

Гүн:

Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар:

Худаг

Тодорхойлсон нь:

Анион	1дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1дм <sup>3</sup> -д байгаа		
	МГ	МГ-ЭКВ	МГ-ЭКВ%		МГ	МГ-ЭКВ	МГ-ЭКВ%
Cl <sup>-</sup>	21.3	0.60	7.2	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	34.6	1.51	18.1
SO <sub>4</sub> <sup>-2</sup>	135.0	2.81	33.9	Ca <sup>++</sup>	<b>104.2</b>	5.20	62.6
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.0	0.00	0.0	Mg <sup>++</sup>	19.5	1.60	19.3
NO <sub>3</sub> <sup>-</sup>	12.0	0.19	2.3	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.0	0.00	0.0
CO <sub>3</sub> <sup>-2</sup>	0.0	0.00	0.0	Fe <sup>++</sup>	0.0	0.00	0.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	286.7	4.70	56.6	Fe <sup>+++</sup>	0.0	0.00	0.0
Дүн	455.0	8.31	100.0	Дүн	158.3	8.31	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын

нийлбэр:

470.0 мг/дм<sup>3</sup>

Ерөнхий хатуулаг

6.80 мг-экв/дм<sup>3</sup>

pH: 7.30

Исэлдэх чанар:

2.72 мг/дм<sup>3</sup>

Физик шинж чанар

Тунгалаг: &gt;30 см

Үнэр: үгүй

Өнгө: үгүй

Амт: \*\*\*

Анион катионуудын

нийлбэр: 613.3 мг/дм<sup>3</sup>

EC: 806 μS/cm

TDS: 448 ppm

Тунадас: үгүй

Булингаршил: 0.0 NTU


HCO<sub>3</sub><sup>-</sup>57 SO<sub>4</sub><sup>2-</sup>34 Cl<sup>-</sup>7Усны найрлагын томъёо: M<sub>0.6</sub> \_\_\_\_\_Ca<sup>2+</sup>63 Mg<sup>2+</sup>19 Na<sup>+</sup>+K<sup>+</sup>18

## Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс кальцийн ион нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018"-д заасан хэмжээнээс ялимгүй их байгаа учир унданд зөөлрүүлж хэрэглэх хэрэгтэй.

**Жич:** Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Шинжилгээг

Хийсэн: Химич, ЭШДА: Магистр (M.Sc)  /Ц.Эрдэнэцэцэг/Хянасан: УШ Лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D)  /Б.Одсүрэн/





ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
 ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН  
 УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2021 оны 08 сарын 04 өдөр  
 Шинжилгээ хийсэн: 2021 оны 08 сарын 06 өдөр  
 Сорьц авсан газрын нэр: Төв аймаг, Сэргэлэн сум, Баруун Уртын алтны уурхай  
 Ундны усны зөөврийн ёмкость, шүүлтүүрээр дамжин гарсан ус  
 Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "ЭВЭЖ" ХХК

Солбицол: X= Гүн:  
 Y= Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Шүүсэн ус

Тодорхойлсон нь:

Анион	1дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl <sup>-</sup>	21.3	0.60	7.4	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	32.3	1.41	17.3
SO <sub>4</sub> <sup>2-</sup>	135.0	2.81	34.7	Ca <sup>2+</sup>	<b>102.2</b>	5.10	62.9
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.0	0.00	0.0	Mg <sup>2+</sup>	19.5	1.60	19.7
NO <sub>3</sub> <sup>-</sup>	12.0	0.19	2.4	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.0	0.00	0.0
CO <sub>3</sub> <sup>2-</sup>	0.0	0.00	0.0	Fe <sup>2+</sup>	0.0	0.00	0.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	274.5	4.50	55.5	Fe <sup>3+</sup>	0.0	0.00	0.0
Дүн	442.8	8.11	100.0	Дүн	154.0	8.11	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын

нийлбэр: 459.5 мг/дм<sup>3</sup>  
 Ерөнхий хатуулаг 6.70 мг-экв/дм<sup>3</sup>  
 pH: 7.63  
 Исэлдэх чанар: 1.28 мг/дм<sup>3</sup>

Анион катионуудын


нийлбэр: 596.8 мг/дм<sup>3</sup>  
 EC: 802 µS/cm  
 TDS: 446 ppm

Тунгалаг: >30 см  
 Өнгө: үгүй


**Физик шинж чанар**

Үнэр: үгүй  
 Амт: \*\*\*

Тунадас: үгүй  
 Булингаршил: 0.0 NTU




Усны найрлагын томъёо: M<sub>0.6</sub>




**Дүгнэлт**

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар ус байна. Анхны устай харьцуулахад нийт эрдэс, хатуулгийн агууламж бараг өөрчлөлтгүй байна.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Шинжилгээг Хийсэн: Химич, ЭШДА: Магистр (M.Sc)  /Ц.Эрдэнэцэцэг/

Хянасан: УШ Лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D)  /Б.Одсүрэн/

**Усан орчны хяналтын шинжилгээний ерөнхий дүгнэлт, зөвлөмж**

“ЭРДЭНЭ ДОРНО” ХХК-ний хүсэлтээр БОННУ-ний хэрэгжилт, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу Баруун уртын алтны уурхай орчмын ус, хөрс, агаарын шинжилгээ судалгааг хийж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

- “Эрдэнэ дорно” ХХК-ний Баруун-Баруун уртын алтны уурхайн орд газрын нутаг дэвсгэр нь Усны нөхөн сэлбэгдэх нөөцийн хувьд *“хэвийн дундаж устай”*, газрын доорх усны Гидрогеологийн мужлалаар *“Монголын төв хэсгийн муж”*-д хамаарах ба уурхай орчимд гадаргын ус үндсэндээ байхгүй, уурхайн болон ажилчдын суурин орчимдоо өөрсдийн хэрэгцээнд зориулж цооног гаргаж ашигладаг байна.
- Усны нөөцийн хяналтын хувьд Ус ашиглах дүгнэлтийг “Монгол Ус” ТӨҮГ-аар гаргуулж, Хэрлэн голын сав газрын захиргаатай гэрээ хийсний үндсэн дээр, ус ашигласны төлбөрийг Төв аймагт төвлөрүүлдэг байна.
- Бид тус уурхайн 8 усны сорьцонд химийн 14, бохирдлын 7, физикийн 5, 4 усны сорьцонд бичил элементийн 53 үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийж, холбогдох стандарт, нормуудтай харьцуулж дүгнэсэн болно.
- Ундны усны цооногийн хувьд зохимжтой хэмжээнээс давсан хатуувтар устай бөгөөд усан дахь кальцийн ион нь *“Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018”* стандартад заасан хэмжээнээс ялимгүй их байсан учир хүний унданд зөөлрүүлж хэрэглэвэл зохимжтой гэж үзсэн.
- Ажилтдын унданд зориулж зөөврийн усан сангийн гарах цоргонд ус шүүх төхөөрөмж тавьсан шүүлтүүр нь усны хатуулгийг төдийлөн шүүгээгүй байна.
- Алт угаах технологид сэлбэлтийн журмаар ашиглаж буй хойд цооногийн ус нь *“Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийг хамгаалах аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018”* стандартын шаардлага хангаж байгаа бол урд цооногийн усны ерөнхий хатуулаг болон кальцийн ион нь уг стандартад зааснаас их байна.
- Бичил элементүүдийн дүнгээр харьцуулах стандартаас давсан үзүүлэлт үндсэндээ байхгүй гэж үзэж болохоор боловч ураны агууламж харьцангуй илрэлтэй байна. 2019 онд энэ үзүүлэлт стандартаас даваагүй, бага агууламжтай байсны гадна ундны усны стандартад 30 мкг/л хүртэлхийг зөвшөөрдөг байна. Иймд цаашид мөн л ураны агууламжийг хянаж байх шаардлагатай. Харин 2019 оны шинжилгээгээр хойд талын алт угаах төхөөрөмжөөс гарсан усанд Ванадийн агууламж (V) өндөр илрэлтэй гарсныг эргэлзээтэй дүн учир цаашид тодруулах шаардлагатай гэж үзэж байсан ба энэ удаагийн шинжилгээгээр бүгд бага агууламжтай байна. Цаашид хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд эдгээр үзүүлэлтүүдийг тогтмол хянуулж байх шаардлагатай.

### 1. Хөрсний шинжилгээ



ХӨРС СУДЛАЛЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**

Монгол улс, Улаанбаатар-16081, Баянгол дүүрэг  
6-р хороо, 10 хороолол, 65 байр А корпус  
Утас/Факс 77278899, 77288899  
E-mail: soil\_lab@g-mongol.mn

Дугаар: 21/2822

Дээж авсан огноо: 2021 он 08 сарын 05

Шинжилгээ хийсэн огноо: 2021 он 08 сарын 05-9

Дээж авсан газрын нэр: Төв аймаг, Сэргэлэн сум, Баруун уртын алтны уурхай,

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “ЭВ ЭЖ” ХХК

Харилцах утас: : 99006911

#### Хөрсний хүнд металл


№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/ /Цайр/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	21/6050	эфелийн шороо A14147	-	28.2	ND	32.7	59.1	72.1	17.3
2	21/6051	эфелийн шороо A12125	-	15.7	ND	22.2	48.9	65.5	33.4
3	21/6052	хогийн цэгийн ойролцоо	0-5	32.4	ND	24.8	35.9	42.1	10.9
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

\*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Чанарын менежер:  Г.Цоггэрэл /MS.c/

Задлан шинжээч:  О.Дагвийжалам /MS.c/

Х. Жаргалмаа

Дээжний хариу хүлээн авсан: Гарын үсэг:



**ХӨРС СУДЛАЛЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**

Монгол улс, Улаанбаатар-16081, Баянгол дүүрэг  
6-р хороо, 10 хороолол, 65 байр А корпус  
Утас/Факс 77278899, 77288899  
E-mail: soil\_lab@g-mongol.mn

Дугаар: 21/2821

Дээж авсан огноо: 2021 он 08 сарын 05

Шинжилгээ хийсэн огноо: 2021 он 08 сарын 05-9

Дээж авсан газрын нэр: Төв аймаг, Сэргэлэн сум, Баруун уртын алтны уурхай, waypoint-30

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “ЭВ ЭЖ” ХХК

Харилцах утас: 99006911

**Хөрсний химийн задлан шинжилгээний дүн**

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	21/6046	шимт хөрсний овоолго	-	8.25	0.11	0.233	1.21	0.96	10.0	4.0	1.5	23
2	21/6047	нөхөн сэргээлтний талбай	-	7.91	0.10	0.218	1.16	0.00	12.7	5.3	1.9	22
3	21/6048	Эрүүл газар	8-10	7.12	0.05	0.107	3.79	0.00	15.8	8.9	4.0	34
4	21/6049		10-40	8.01	0.05	0.111	0.35	0.00	7.0	3.0	0.8	11

**Хөрсний механик бүрэлдэхүүн**

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	21/6046	шимт хөрсний овоолго	-	11.6	38.8	37.0	5.7	6.1	0.7	12.5
2	21/6047	нөхөн сэргээлтний талбай	-	18.4	27.6	34.1	7.6	6.9	6.3	20.8
3	21/6048	Эрүүл газар	8-10	19.8	32.5	31.6	6.6	7.2	2.3	16.1
4	21/6049		10-40	8.9	21.7	44.2	8.1	10.7	6.3	25.1

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуульбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Чанарын менежер:

Г.Цогтгэрэл /MS.c/

Задлан шинжээч:

О.Дагвийжалам /MS.c/

Х.Жаргалмаа

Дээжний хариу хүлээн авсан: Гарын үсэг:



**Хөрсний хяналтын шинжилгээний талаар**

- Байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийж, хөрсний хяналтын цэгүүдийг тогтоож өглөө.
- “ЭРДЭНЭ ДОРНО” ХХК-ний алт олборлох үйл ажиллагааны үед уурхайн орчмын талбайд 2021 онд хийгдсэн судалгаагаар уурхайн малталтанд өртөөгүй эрүүл газрын хөрс ерөнхийдөө шим тэжээлийн элементээр сайн хангагдсан, бүтцийн хувьд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, хөрсний шим тэжээлийн элементүүдийн агууламж болон ширхэгийн бүрэлдэхүүний хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй ерөнхийд нь авч үзвэл анхаарал татахаар хэлбэлзэл доройтол ажиглагдахгүй байна.
- Харин суурин газрын хөрс эрүүл газрынхтай харьцуулахад тодорхой түвшинд доройтож байна. Тиймээс тосгонд мод бут тарьж хөрс элэгдэл, эвдрэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх цаашилбал агаарын бохирдлоос хамгаалах нь зүйтэй. Хог хаягдлын менежментийг сайжруулах, элэгдэл, эвдрэлд өртсөн талбайг цаг алдалгүй нөхөн сэргээж тодорхой хэмжээгээр ногоон байгууламжийг бий болгохыг зөвлөж байна.
- Хөрсөн дэх хүнд металын агууламж жил бүр хэлбэлзэж байна. Одоогоор хортой хүнд металын агууламж бага хэмжээгээр илэрч “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартын нормын хэм хэмжээнд хэлбэлзэж байгаа тул хүнд металын бохирдолгүй гэж үзэж болно.
- Эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт газар дээр нь ажиглахад боломжийн хэмжээнд явагдаж байна.

### **3. Агаарын судалгаа**

#### **Агаарын чанарын стандарт, арга аргачлал:**

- MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага  
Энэхүү стандартын зорилго нь Монгол улсын хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах, сурах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор гадаад, дотоод орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоож мөрдүүлэхэд чиглэгдэнэ.
- MNS 3384:82 Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага.
- MNS (ISO) 5365:2004 Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох
- MNS 17.2.5.12:88 Агаарын дахь хүхрийн хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга
- MNS 17.2.5.11:88 Агаарын дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга

#### **Төслийн талбайн хүрээлэн буй орчны агаарын чанар**

Агаарын бохирдол нь тухайн хугацааны цаг агаар, уур амьсгалын онцлогоос шууд хамаардаг. Тухайн орчинд агаар бохирдуулагчийн эх үүсвэрүүд ховор хэдий ч ойр орчны авто замаар зорчих тээврийн хэрэгсэлээс үүсэлтэй азотын давхар исэл, тоосонцорын бохирдол салхиар туугдан очих үзэгдэл ажиглагдаж байна.

Судалгааны үед агаарын хөдөлгөөний чиглэл ихэнхдээ баруун, баруун өмнө зүгээс салхитай байсан ба салхины хурд 1-3 м/сек. Хөрсний гадаргын байдал чийлэгдүү, цаг агаарын байдал тогтуун, агаарын үзэгдэлгүй, агаарын температур 16.1оС, даралт 875-877 гПа, хуурайшилт багатай, агаарын харьцангуй чийгшил 50-55% байлаа.

Энэ уурхайд 2021 оны 8 сарын байдлаар нэг прибор ажиллаж байв. Судалгааны үед газрын гадарга чийгтэй байсан тул тээвэрлэлт, шороо асгалт, олборлолт явагдаж байсан хэдий ч ерөнхийдөө агаарын бохирдолгүй байлаа.

#### **Судалгааны үр дүн**

##### ***Агаарын ажиглалтын цэг 1: Баруун уртын олборлолт явуулж буй талбай***

Энэ талбайд өдөр 13<sup>00</sup> цагт агаар дахь том ширхэглэгт тоос /PM10/, хүхэрлэг хий, азотын давхар исэлийн агууламжийг тодорхойлох сорьц авч, дуу чимээний түвшингийн хэмжилт хийсэн.

Уурхайн талбайд орчны агаар дахь гол бохирдуулагчийн нэг тоосны агууламжид нөлөөлөх хүний үйл ажиллагаанаас үүсэлтэй удаан хугацааны бохирдуулах хүчин зүйл байхгүй байсан хэдий ч тухайн орчинд цаг уурын нөхцлөөс хамаарч суларсан хөрс бүхий газар, өвс ургамлын хаталт, хүн, малын хөлийн тоос зэргээс гадна эл уурхайн ачих, малтах, тээвэрлэх зэрэг том оврын техникүүдийн үйл ажиллагаа, хээрийн шороон замаар явах тээврийн хэрэгслийн дугуйнаас босох тоос тухайн орчмын тоосонцорын агууламжийг ихэсгэх гол эх үүсвэр болж байгаа нь ажиглагдсан.





Уурхайн бүсийн агаарын хэмжилт

Тоосны бохирдол салхины чиглэл, хурднаас хамаарч ялангуяа намар ба хаврын улиралд хөрсний хуурайшилттай саруудад тухайн уурхайн талбайд тээвэрлэлт буулгалтын үед үүсэх бөгөөд салхиар туугдан сууршлийн хэсэг, ажил үйлчилгээний төрлөөс шалтгаалан ойр орчмын зарим хэсгүүдийн агаарын чанарт нөлөөлөхөөр байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Буурлын хөндийн уурхайн бүсэд нийт тоосны агууламж нэг удаагийн тухайн үеийн хэмжилтээр  $0,215 \text{ мг/м}^3$ -д хүрч хүлцэх хэм хэмжээнээс давсан бохирдол илэрсэнгүй /хүснэгт 3.1/.

Хяналтын цэгүүд орчмын агаар дахь нийт тоосны дундаж агууламж

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Нийт тоосны агууламж, $\text{мг/м}^3$
1	Уурхайн бүс /У 107°27'23.3" Ө 47°33'18.0"/	2021.08.04	0.215
2	Тосгоны орчим /У 107°27'14.3" Ө 47°32'55.2"/	2021.08.04	0.075
<b>Агаарын чанарын стандарт</b>			<b>0.500</b>

Агаарын хяналт шинжилгээний дарагийн үзүүлэлтүүд болох агаар дахь хүхэрлэг хийн 30 минутын дундаж агууламж  $0.013 \text{ мг/м}^3$ , азотын давхар ислийнх  $0.029 \text{ мг/м}^3$  бөгөөд Баруун уртын уурхайн бүсэд тухайн үеийн хэмжилтээр стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

### **Агаарын ажиглалтын цэг 2: Уурхайн ажилчдын суурингийн орчим**

Ажилчдын тосгоны талбайн хувьд тоосны бохирдол тухайн үеийн үйл ажиллагаанаас шалтгаалан харьцангуй бага гарч бохирдол илрээгүй байгаа нь шинжилгээний дүнгээс харагдаж байна. Гэхдээ агаарын хөдөлгөөний чиглэл болон хурдаас ихээхэн хамаарч эвдэрсэн талбай, хөрс хуулалт, овоолго, тээвэрлэлт, автозам, хөрсний гадаргаас үүсэх тоос салхиар тархан дэгдэх үзэгдэл ажиглагддаг.



Тосгоны агаарын төлөв

Уурхайн ажилчдын тосгоны ойролцоох агаар дахь хүхэрлэг хийн болон азотын давхар ислийн агууламж уурхайн бүсийнхтэй харьцуулбал ерөнхийдөө ойролцоо дүн гарч байна

*Агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж*

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	SO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup>	NO <sub>2</sub> , мг/м <sup>3</sup>
1	Уурхайн бүс	2021.08.04	0.013	0.029
2	Ажилчдын тосгон	2021.08.04	0.012	0.022
<b>Агаарын чанарын стандарт MNS 4585:2016</b> /20минутын хэмжилт/			<b>0.450</b>	<b>0.200</b>

#### Дуу чимээний хэмжилтийн үр дүн

Агаарыг бохирдуулах хими, физик, биологийн хүчин зүйлүүд байдгаас физикийн хүчин зүйл нь тэр болгон хүнд үзэгдэж мэдрэгддэггүй боловч хүний эрүүл мэндэд тодорхой хор хөнөөл учруулдаг онцлогтой. Агаарт нөлөөлөх физикийн хортой нөлөөнд: чимээ шуугиан, чичиргээ доргион, цахилгаан соронзон долгио, цацраг идэвх зэрэг хүчин зүйл ордог юм. Төслийн талбайд сонгосон агаарын чанарын ажиглалтын цэгт тухайн орчны дуу чимээнд үзүүлэх нөлөөллөөс хамаарсан хэмжилтийг хийж дүнг нэгтгэлээ.

Монгол улсын Агаарын чанарын стандарт /MNS-4585-2016/-д дуу чимээний зөвшөөрөгдөх түвшинг өдрийн цагаар 60дБ, шөнийн цагаар 45дБ-аас тус тус доош байхаар тогтоосон байдаг. Хүн ам ямар нэг хэмжээгээр суурьшсан газар дуу чимээг хэмжих асуудал тур дундаа барилга байгууламж, уул уурхай болон үйлдвэрийн бүсийн нутаг дэвсгэрийн дуу чимээний түвшинг тогтоож эрүүл ахуйн нормын зөвшөөрөгдөх хэмжээнээс давуулахгүй байх шаардлагыг тавьдаг.

Дуу чимээний түвшин 90дБ хүрсэн газар 8 цагаас илүү хугацаагаар байхад хүний эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөх ба 120дБ хүрч 0.6 минутаас илүү үргэлжлэхэд тэнд байгаа хүний сонсголын эрхтэн нь гэмтэх магадлалтай.

Агаарын чанарын ажиглалтын цэгээс дуу чимээний түвшний хэмжилтийг өдрийн цагт үйл ажиллагаа явуулж байхад хийсэн ба хэмжилтүүдийн дундаж утгыг тодорхойлоход 64.5 ДБА гарч агаарын чанарын стандартаас ялимгүй давж илэрлээ. Шинжилгээний үр дүнг тайлангийн ард хавсаргав.

**Агаарын чанарын судалгааны дүгнэлт**

Агаарын чанарын төлөв байдалд хяналтын шинжилгээ хийж, одоогийн түвшнийг тогтоосноор цаашид явуулах үйл ажиллагаанд авах аливаа арга хэмжээг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэхэд тус дөхөм болох юм. Ялангуяа байгаль орчныг хамгаалах буюу байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, уг төслийн үйл ажиллагаанаас үүсэх бохирдлыг багасгах, арилгах зэрэгт нөлөөлөх юм.

“Эрдэнэ дорно” ХХК-ний олборлолт явуулж буй Баруун уртын алтны уурхайн орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж судалгааны хугацаанд Монгол Улсын Агаарын чанарын стандарт (MNS 4585:2016)–д заасан хүлцэх хэм хэмжээнээс даваагүй байна.

Цаг агаарын эрс тэс нөхцөлтэй Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах Баруун уртын алтны уурхайн агаарын чанарт агаар бохирдуулах эх үүсвэрийн үйл ажиллагааны эрчимжилтээс гадна цаг, хоног, сар, улирал, жилийн цаг агаарын нөхцөл нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл бохирдуулагчдын газрын гадарга орчмын агаарт хуримтлагдах ба сарнигдах түвшин нь тухайн үеийн цаг агаарын нөхцлөөс тодорхой хэмжээгээр хамаардаг. Иймд энэхүү төслийн талбайн зарим хэсэгт агаарын урсгалаар бохирдол зөөгдөж тухайн нутаг дэвсгэрийн орчны агаарын чанарт харилцан адилгүй нөлөөлөхийг үгүйсгэхгүй юм.


Цаашид хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу төслийн хэрэгжилтийн явцад тухайн орчны агаарын чанарын судалгаа-шинжилгээг жилд 1-с доошгүй удаа хийлгэж төслийн үйл ажиллагаанаас үүсэлтэй агаар бохирдуулахаас сэргийлэх болон бохирдол илэрсэн тохиолдолд өмнөх БОННУ-ний тайлангийн БОМТ-д тусгасан арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх нь зүйтэй.



**MNS**  
Accreditation  
system  
TUV  
MNS ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043 Улаанбаатар, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: clem@namem.gov.mn



**БАЙГАЛЬ**  
Орчин Ажиллагааны Төв Лаборатори

---


**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2021/199
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “ЭВ ЭЖ”ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2021.08.04
Дээжийн тодорхойлолт	: Төв аймаг, Сэргэлэн сум “Эрдэнэ Дорно ХХК”, Алтны уурхай
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17.2.5.12:88, MNS 17.2.5.11:88, DUSTRAK8530
Шинжилсэн огноо	: 2021.08.06
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м³	Азотын давхар исэл мг/м³	Нийт Тоос /TSP/ мг/м³	Дуу чимээ /дБА/
1	N 47° 33' 18.0" E 107°27' 23.3"	VIII/4	12:40	0.013	0.029	0.215	79
2	Кэмп орчим	VIII/4	13:10	0.012	0.022	0.075	50
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>	<b>60</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн техникч

Хянаж баталгаажуулсан::  
Агаарын хэсгийн инженер



Д.Сувд

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй


**ЗӨВЛӨМЖ****Айл өрхийн зориулалттай усны шүүлтүүрүүд****Элсэн шүүлтүүр**

Уг төхөөрөмж нь орчин үеийн техник технологийн ололтыг шингээж туршилтаар үр дүн нь баталгаажсан, Монгол орны нөхцөлд ашиглагдах шаардлагыг бүрэн хангасан бөгөөд 2000 оноос эхлэн ашиглагдаж байна. Олон улсын стандартын байгууллагын / 1509001/ чанар стандартын шаардлага хангасан. Усны өнгө, үнэр, амт, булингар зэрэг физик механик хольц болон нян, бактерийг шүүх чадвартай. Өртөг хямд, энгийн ажиллагаатай.



*Элсэн шүүлтүүрийн загвар.*

Элсэн шүүлтүүр хэдэн зуун жилийн турш олон нийтийн ус цэвэрлэгээнд хэрэглэж ирсэн уламжлалт хэлбэр юм. Элсэн шүүлтүүр нь жижиг ба айл өрхийн хувьд хэрэглэхэд тохиромжтой. Шүүлтүүрийн сав нь бетон, хуванцар эсвэл ямар ч ус нэвтэрдэггүй, зэвэрдэггүй, эрүүл мэндэд хоргүй материалаар хийгдсэн байна. Савыг шигшиж угааж хийсэн элс хайргаар дүүргэнэ (үүнийг шүүлтүүрийн орчин гэнэ). Угааж цэвэрлэнэ.

**Керамик шүүлтүүр /шавар/**

“Шавар” усны шүүлтүүрийг хүн төрөлхтөн олон зуун жилийн өмнөөс ашиглаж иржээ. Зарчим нь: ус шүүх савныхаа ёроолд шүүгч материал бүхий шавраа /керамикаа/ хийж, үүнийгээ тусгай цорго бүхий ус хадгалах саван дээр байрлуулж, шүүсэн усаа цоргоор авна. Шүүгүүр материал болох керамикийг тусгай технологийн дагуу хийдэг ба орц нь элбэг олдоцтой орон нутгийн материал учир өртөг харьцангуй хямд, энгийн ажиллагаатай.

*Керамик шүүлтүүрийн загвар*

Нянгийн эсрэг үйлчилгээтэй мөнгөний коллойд нэмж эмгэг төрөгчийг шүүж, шавар шүүлтүүрт нян үржихээс сэргийлэх боломжтой. Усны амт, өнгө, үнэрийг сайжруулахын зэрэгцээ усан дахь нянг шүүхэд ихээхэн үр дүнтэй боловч усанд ууссан химийн бодисыг шүүхэд элсэн шүүлтүүрийн адил үр дүн багатай. Шүүлтүүрийг авч цэвэрлэх боломжтой.

**Мембран шүүлтүүр**


Мембран гэдэг нь нимгэн, нүдэнд үл үзэгдэх сүвтэй шинэ төрлийн ус шүүх зориулалтын материал юм. Мембраны нүхээр усны молекул нэвтрэн гарч харин өвчин үүсгэгч болон бусад бохирдуулагч бодисууд мембранд шүүгдэж зайлуулагддаг. Мембран шүүлтүүр нь цэвэр химийн аргаар гарган авсан хагас нэвчилттэй полимер эд байдаг. Мембран шүүлтүүрийг мембраны нүх сүвний хэмжээгээр ангилж болно.

Хүснэгт 59. Мембран шүүлтүүрийн төрөл.

№	Шүүлтүүрийн төрөл	Сүвний хэмжээ (µm / nm)
1	Бортогот мембран шүүлтүүр (MCF)	1-100 µm (100-10000 nm)
2	Микрошүүлтүүр (MF)	0.1-10 µm (1-1000 nm)
3	Ультра шүүлтүүр (UF)	0.01-0.1 µm (1-100 nm)
4	Нано шүүлтүүр (NF)	<0.001 µm (<1 nm)
5	Урвуу осмосис (RO)	<0.001 µm (<1 nm)



Мембраны нүхээр усны молекул нэвтрэн гарч харин өвчин үүсгэгчид болон бусад бохирдуулагч бодисууд мембранд шүүгдэж зайлуулагддаг. Микро шүүлтүүр болон ультра шүүлтүүрийн хувьд хүндийн хүч нь усны урсгалыг шүүлтүүрээр дамжуулахад хангалттай даралт болдог. Ультра мембран шүүлтүүр нь элсэн болог керамик шүүлтүүрийн адил усан дахь механик хольц, бактер, эгэл биетэн, шимэгч хорхой, зарим вирус зэрэг том, хүнд хэсгүүдийг шүүх чадвартай.



Бортогот мембран шүүлтүүр



Мембран фильтрийн төхөөрөмжөөр эдгээр элементүүдийг шүүх боломжтой. Мембран фильтр бүхий айл өрхийн зориулалттай маш олон хийц, загварын төхөөрөмжүүд зах зээлд худалдаалагдаж байгаа. Аливаа шүүх төхөөрөмжийн филтэрүүд нь зөвхөн хүйтэн усанд зориулагдсан байдаг ба шүүсэн усыг удаан хадгалж болохгүйг хэрэглэгчид анхаарах хэрэгтэй.

**Микро шүүлтүүр:** Нүх сүв нь зарим вирус өвчин үүсгэгчүүдээс том байдаг учраас ундны ус цэвэрлэхэд хангалтгүй байдаг. Микро шүүлтүүрийг олон шатлалтай цэвэрлэгээний системийн урьдчилсан цэвэрлэгээ болгож хэрэглэдэг.

**Ультра шүүлтүүр:** Өрхийн ундны усны цэвэрлэгээнд хамгийн түгээмэл хэрэглэгддэг мембран шүүлтүүр юм. Ультра шүүлтүүр нь төмөр болон бактер шүүнэ. Ультра фильтр ашиглах хугацаа 12 сар. Ундны уснаасаа нянгаар бохирдохгүй байх боломжийг бүрдүүлдэг. Усан дахь 0,01-1,001 микроны хэмжээтэй нян, бичил биетүүдийг (Giardia, Cryptosporidium, E-coli гэх мэт) шүүх ба хүний биед хэрэгцээтэй эрдэс бодисыг хадгалан үлдээнэ.

**Нано шүүлтүүр:** Микробиологийн бохирдлыг арилгахад маш үр дүнтэй байдаг боловч эдгээр шүүлтүүрүүд нь ерөнхийдөө усыг давсгүйжүүлэх, уссан бохирдуулагч зайлуулах шаардлагатай байгаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

**Мөнгөний ионоор баяжуулж нано технологиор хийсэн шүүлтүүр:** Ажиллах хугацаа 12 сар. Нано технологи ашиглан мөнгөний ионоор баяжуулсан шүүлтүүр нь 0.05-0.09 микроны нарийвчлал бүхий шүүлтүүр усан дахь хүнд металиуд болон хорт бодисыг 95% хүртэл шүүж бактери нянгийн эсрэг хүчтэй үйлчилж устгах ба хүний биед хэрэгцээтэй эрдэс бодисыг хадгалан үлдээнэ.

**Урвуу Осмосис:** RO-membrane- Урвуу осмос, Reverse osmosis- ашиглах хугацаа 18 сар. Усан дахь 0.01-0.0001 микрон бүхий өндөр нягтшилтай тусгай материалаар усыг нэвтрүүлэхэд зөвхөн усны молекулиуд нэвтэрч чадах дээд зэргийн цэвэршүүлэлт явагдах тул усан дахь бичил биетүүд, хүнд металлууд, органик болон органик бус бохирдлыг 98% хүртэл цэвэршүүлнэ.

**Төвийн шугамд холбодог мембран шүүлтүүрүүд:** Дэлхий нийтийг түгшээж байгаа асуудлын нэг бол үйлдвэрлэлийн хөгжил дэвшлийг даган гарч ирж буй экологийн бохирдол тэр дундаа цэвэр усны асуудал билээ. Манай орны хувьд гүний цэнгэг устай боловч дамжуулах хоолойгоор дамжин хэрэглэгчдэд хүрэх явцдаа элдэв хог бохирдлоор бохирдон зэв хог, механик хольц, илүүдэл хлор, химийн хорт нэгдлүүд, үнэр амт янз бүрийн өвчний эх үүсвэр болдог. Усан дахь төмрийн агууламж ихэдсэнээр амт нь өөрчлөгдөж хүний арьсанд муугаар нөлөөлөхөөс гадна цусанд өөрчлөлт оруулж улмаар харшилд хүргэх аюултай бөгөөд хатуулаг ихэдвэл хүний биед давс хуримтлагдаж үе мөчний өвчин, бөөр, цөс, давсагны чулуу үүсгэдэг. Тэгвэл энэ бүгдээс хамгаалах усны чанарыг сайжруулах олон төрлийн хийц, загвар, янз бүрийн хүчин чадал бүхий төхөөрөмжүүд бий болжээ



Шугам сүлжээнд холбодог мембран шүүлтүүрүүд.

Онцлог шинж чанарууд:

Ус нөөцлөх хангалттай багтаамж, ус цэвэршүүлэх өндөр хүчин чадал: цагт 30л. 3 шүүлтүүр бүхий 5 шатлалт шүүх систем

1.1-р шатлал: Цаасан шүүлтүүр

2-р шатлал: Нүүрсэн шүүлтүүр

2.3-р шатлал: Нүүрсэн шүүлтүүр

4-р шатлал: Керамик

3.5-р шатлал: Мембран (Мяндсан) шүүлтүүр



Fresh water-ийн усны шүүлтүүр нь гал тогооны шүүгээн доор суурилуулж өгснөөрөө хамгийн бага зайг эзлэх шийдлийг бүрдүүлж өгсөн.

Эдгээр төхөөрөмжүүдийн загвар хийц, хүчин чадал, шатлал нь өөр ч, зарчим нь төстэй.

**Ус зөөлрүүлэгч:** Энэхүү төхөөрөмж нь орчин үеийн техник технологийн ололтыг шингээж, туршилтаар үр дүн нь баталгаажсан, Монгол орны нөхцөл шаардлагыг бүрэн хангасан бөгөөд 2000 оноос эхлэн ашиглагдаж байна. Манай эрдэмтдийн бүтээсэн технологитой адил зарчимтай боловч автомат ажиллагаатай учир өртөг өндөртэй. Олон улсын сдандартын байгууллагын /1309001/ чанарын шаардлага хангасан Төхөөрөмжийн дээд талд байрлах компьютерт усны шинжилгээний дүнг үндэслэн ажиллагааны горимыг оруулдаг. Усны хатуулгийг бууруулахын зэрэгцээ усанд агуулагдах төмөр, хар тугалга, бари болон цацраг идэвхит элемент, хүнд металлуудын агууламжийг бууруулдаг. Зөөлрүүлэгчийн автомат удирдлага нь 24 Вт-оор ажилладаг тул цахилгаан эрчим хүчний зардал бага байдаг.

Ашиглалт эдэлгээний хугацаа 10-аас доошгүй жил Зөөлрүүлэх бодис (КУ2)-ыг 1-2 жилд цэнэглэнэ.

Ус зөөлрүүлэгч ECR-3000-R20 төхөөрөмжийн хүчин чадал.

Хүчин чадал (тн/цаг)	5.0
Ажлын даралт (кг/см <sup>2</sup> )	2-7
Ажиллах хэм (С <sup>0</sup> )	5-45
Гарах хоолойн диаметр (мм)	40
Ачааллах давсны хэмжээ (кг)	66.0
Төмрийн дээд хэмжээ (мг/л)	15
Түлгүүр үе хадан цагааны хэмжээ (кг)	4
Сэргээлтэнд хэрэглэх усны хэмжээ (л)	110
Зөөлрүүлэх бодисын хэмжээ (кг)	14.5
Гадна овор хэмжээ (мм)	115*51*36
Хатуулгийн дээд хэмжээ (мг-экв/л)	30

**Зориулалт:** Уг төхөөрөмж нь хоногийн хүчин чадал ихтэй тул төв суурин газар, сумын төвийн ус түгээх байр, амралт сувиллын газар, аялал жуулчлалын бааз, спирт, архи, ундаа, эмийн үйлдвэр, эмнэлэг, зочид буудал гэх мэт газруудад тохиромжтой.



Ус зөөлрүүлэгч ECR-3000-R20

Түүнчлэн энэ төрлийн БНСУ-ын “Fresh Water” компанид үйлдвэрлэгдсэн “Housing” маркийн төрөл бүрийн ус шүүх төхөөрөмжүүд байдаг.

Ус шүүх төхөөрөмжүүд нь айл өрхийн зориулалттай, шугам сүлжээнд холбогдсон, усны эх үүсвэр дээр суурилуулах болон, зөөврийн гэх мэт маш олон сонголттой байдаг бөгөөд гагцхүү өөрийн хэрэглэж буй усныхаа чанарт тохирсон шүүгчийг хэрэглэх нь хэрэглэгчийн сонголт байх ёстой. Иймд хүн бүр ууж байгаа усныхаа чанарт анхаарч, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэн дүгнэлт гаргасны дараа усны чанар нь ямар байгаа ямар шүүлтүүр хэрэглэхээ сонгох хэрэгтэй.



**2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг**

**/арга хэмжээ бүрт 2-оос доошгүй орчны фонтой хамт авсан гэрэл зураг хавсаргах/  
Энэ ажлын хүрээнд арга хэмжээний зураглалууд Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт орсон байгаа.**

**3. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг харуулсан зураглалууд**



Уурхайн техникийн нөхөн сэргээлтээр дүүргэлт хийж байгаа үеийн зураг



Уурхайн техникийн нөхөн сэргээлтээр дүүргэлт хийсний дараах тэгшилж буй үеийн зураг





Уурхайн техникийн нөхөн сэргээлтээр дүүргэлт хийсний дараах тэгшилсэн үеийн зураг



Уурхайн техникийн нөхөн сэргээлтийн дараа шимт хөрсөөр хучих эхний үе шат



Шимт хөрсийг тараан тэгшлэх эхний үе шат



Шимт хөрсийг тараан тэгшилж буй үйл явц



Шимт хөрсөөр хучсаны дараах олон наст ургамлын үр суулгаж буй үйл явц







Тариалалтын дараах усалгааны үйл явц



Тариалсан үрний ургалтын эхний үе шат



Тариалсан үрний ургалтын дунд болон сүүл үеийн үе шат





Хулгана барьж буй хярс

**4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ**

2022 онд Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлтийн хэсэг §4-т оруулж өгсөн.

**5. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн зарцуулсан химийн хортой болон аюултай бодисын ашиглалтын дүн мэдээ**

Шатах тослох материалын агуулах: Түлш хадгалах зориулалтаар 25 тонны багтаамжтай ган сав 2 ширхэгийг, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай тус тус хадгалах юм. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.



2021 онд 89 мян. л дизелийн түлш, 2.7 тн масло, тос хэрэглэсэн.

**6. Аюултай хог хаягдлыг устгах, хадгалах арга хэмжээг хэрхэн гүйцэтгэсэн**

Уурхайд дизель түлш, тос тосолгооны материалаас өөр аюултай хорт бодис бүтээгдэхүүн хэрэглэдэггүй. Шатах тослох материалын хаягдлуудыг тухай бүрт савлан авч тухайн хаягдлыг авдаг газруудад өгдөг.

**7. Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг нь хүлээж авсан актын хуулбар Төв аймгийн БОАЖГ-с авна.****8. Хуваарьт болон хуваарьт бус аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан**

Энэ ажлын хүрээнд аудитын ажил хийлгэсэн хугацаа дууссан учир дахин тодотгол хийлгэж байна. Гэрээг хавсаргав.

“И АР ЭМ” ХХК-ний гүйцэтгэсэн “Баруун-Урт алны шороон орд төслийн Байгаль Орчны Аудитын тайлан”-нд дурьдсан асуудлуудыг БОМ-ийн төлөвлөгөөнд тусган үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд хогийн цэгийг байгуулах, уурхайн орчныг эмх цэгцтэй ажиллах, сөрөг нөлөөллүүдийг арилгах, байгаль орчны хяналтыг жил бүр хийлгэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна.

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2022 оны 03 р сарын 11-ний өдөр

№ ...

Улаанбаатар хот

Энэхүү “Ажил гүйцэтгэх гэрээ”/цаашид “Гэрээ” гэх/-г Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлүүдийг үндэслэн нэг талаас Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо Өнөр хотхон 39-р байр 194 тоот хаягтай “Эрдэнэ Дорно” ХХК /цаашид “Захиалагч” гэх/,

нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, SPS оффис, 405-406 тоот хаягтай “И АР ЭМ” ХХК (цаашид “Гүйцэтгэгч”, хамтад нь “Талууд” гэх) нар харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. **Гэрээний зүйл:** Гэрээний дагуу Гүйцэтгэгч нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах MV-014147, MV-012125 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, зэрэгцээ орших Баруун урт, Баруун уртын баруун дээд алтын шороон ордуудыг ашиглах төслийн байгаль орчны аудитын ажлыг /цаашид “Ажил” гэх/ үнийн саналын дагуу холбогдох хууль тогтоомж, журам, аргачлалд заасан нөхцлүүдэд нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

1.2. **Шаардлагатай баримт бичиг:** Хавсралт 01

1.3. **Ажил гүйцэтгэх газар:** “Эрдэнэ Дорно” ХХК-ийн Төв аймаг Сэргэлэн сумын нутаг дахь “Баруун урт” нэртэй алтын шороон орд

1.4. **Хугацаа:** Ажил гүйцэтгэж эхлэх : 2022 оны 3-р сарын 18  
Гэрээт ажлыг хүлээлгэж өгөх : 2022 оны 4-р сарын 08

**Хоёр. Үнэ, төлбөрийн нөхцөл**

2.1. **Гэрээт ажлын нийт хөлс:** Ажлын нийт хөлс 10 сая (төгрөг) байна. Үүнд НӨАТ-с бусад холбогдох татвар, хураамж, бусад бүх зардлууд багтсан эцсийн үнэ бөгөөд цаашид өөрчлөгдөхгүй байхаар Талууд тохиролцов.

2.2. **Төлбөрийн нөхцөл:** Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан төлбөрийн 50%-г гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан, үлдэгдэл 50%-г аудитын тайлан хүлээн авах үед Гүйцэтгэгчийн Голомт банкн дахь 1410004970 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

**Гурав. Захиалагчийн эрх, үүрэг**

3.1. Захиалагч нь энэхүү Гэрээнд заасан ажил үүргийг Гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бөгөөд гүйцэтгэлийг үе шат бүрээр нь хянах эрхтэй.

3.2. Гүйцэтгэгчээс Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.3. Захиалагч нь Гүйцэтгэгчээс Гэрээнд заасан хугацаанд тавьсан шаардлагын дагуу ажил гүйцэтгэх аргын талаар өгсөн заавраа өөрчлөх, түүнчлэн ажлын чанарт муугаар нөлөөлөх нөхцлийг арилгах үүрэгтэй.

3.4. Захиалагч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичиг зэргийг Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу гаргаж өгөх, Гүйцэтгэгчийг төслийн талбай дээр ажлаа хийхэд шаардлагатай нөхцөлөөр хангах үүрэгтэй.

3.5. Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан нөхцөлийн дагуу төлбөрийг төлөх үүрэгтэй.

3.6 Аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал өгөх эрхтэй.



### 3.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй

#### Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч нь гэрээнд дурдсан хугацаанд ажлыг мэргэжлийн түвшинд, бүрэн гүйцэд, үнэн зөв, алдаагүй (холбогдох стандарт, эрх бүхий байгууллагаас тавигдах шаардлагыг бүрэн хангасан алдаагүй) гүйцэтгэх, чанар сайтай биелүүлэх үүрэгтэй.
- 4.2. Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан журмаар Захиалагчаас төлбөрөө шаардан авах эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэгч нь ажлыг шаардлагатай хэмжээнд явуулах үүднээс хууль зүй, удирдлага зохион байгуулалтын талаар Захиалагчаас зөвлөмж, санал авч болно.
- 4.4. Захиалагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах, хохирлоо барагдуулах эрхтэй.
- 4.5. Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэх бөгөөд ажлын гүйцэтгэлийн хөлсийг гэрээнд заасны дагуу ажил үүргийн гүйцэтгэлээр авна.
- 4.6. Гүйцэтгэгч нь Ажлын гүйцэтгэлийн чанар, тайлан, зөвлөмжийн үнэн зөв байдлыг Захиалагч болон аливаа гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцах (мөн буруу, алдаатай, бүрэн бус гүйцэтгэлээс учирсан хохирол, зардлыг бүрэн хариуцна) үүрэгтэй.
- 4.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээ байгуулахгүй байх;

#### Тав. Хариуцлага

- 5.1. **Алданги:** Гүйцэтгэгч нь гэрээний нөхцлийг бүрэн хангасан ажлыг Гэрээний 1.4-д заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгөөгүй, Гэрээгээр тусгайлан хугацаа тогтоож өгсөн үүргээ тухайн цаг хугацаанд нь биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол тухайн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө. Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол Гэрээний 2.1-д заасан үнийн дүнгээс тооцно.
- 5.2. Захиалагч нь төлбөрийг Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй бөгөөд Гэрээний 2.2-т заасан төлбөр төлөх хугацааг 30 хоногоор хэтрүүлсэн бол, тийнхүү хэтрүүлсэн өдрөөс эхлэн төлөөгүй ажлын хөлсний дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алданги төлнө.
- 5.3. **Бусад хариуцлага:** Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчснөөс нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг (гэрээний үнийн дүн, алданги, торгуулиас үл хамааран) хариуцна.
- 5.5. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомж, гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

#### Зургаа. Нууцлал

- 6.1. **Нууцлал:** Талууд Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон харилцан солилцсон мэдээлэл, баримтын нууцлалыг Гэрээ байгуулагдснаас хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд нөгөө Тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардснаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, Гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байхаар тохиролцов.

#### Долоо. Талууд харилцах

- 7.1. Гэрээтэй холбоотойгоор Талууд хоорондоо харилцахдаа дараахь мэдээллийг үндэслэнэ.  
Үүнд:



5.3. БОА-ын дүнг гүйцэтгэгч 1 хувь үйлдэж зөвхөн аудит хийлгэгчид хүлээлгэн өгнө.

**Зургаа. Давагдашгүй хүчин зүйл**

6.1. Гэрээний хугацаанд БОА-ын ажил гүйцэтгэх үед давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи мэт байгалийн гамшигт үзэгдэл, халдварт өвчний тархалт, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо зэрэг нийгмийн нөлөөлөл) тохиолдож гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хугацааг сунгах үндэслэл болно.

6.2. Давагдашгүй хүчин зүйл бий болсон нотолгоог тухайн харьяа газрын төрийн захиргааны байгуулагаас авч болно.

**Долоо. Мэдээллийн нууцыг хадгалах**

7.1. Гүйцэтгэгч нь Аудит хийлгэгчээс хүлээн авсан нууцад тооцогдох мэдээллийг бусад байгууллага, хувь хүмүүст зарлан тараахгүй бөгөөд гэрээнд дурьдсан зорилгоос өөр аливаа хэлбэрээр ашиглахгүй.

7.2. Гүйцэтгэгч нь аудит хийлгэгчийн мэдээллийн нууцыг өөрийн компанийн нууцын зэрэглэлд авч үзэж бусдад задруулах, ашиглуулахаас зайлсхийж, хариуцлагатайгаар хамгаална.

**Найм. Хүлээх хариуцлага**

8.1. Гүйцэтгэгч нь БОА-ын тайлан, дүн мэдээний үнэн зөв байдлыг хариуцна.

8.2. Гүйцэтгэгч нь БОА-ыг холбогдох арга, аргачлалын дагуу гүйцэтгээгүйн улмаас байгаль орчинд учирсан аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

8.3. Аудит хийлгэгч нь БОА-ын зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүй, дүгнэлт зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг харьяа газрын байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцна.

**Ес. Бусад заалт**

9.1. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцож, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, гэрээнд нэмэлтээр тусгана.

9.2. Аливаа маргааныг талууд үл маргах журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын шүүхээр эцэслэн шийдвэрлэнэ.



АУДИТ ХИЙЛГЭГЧ

“Эрдэнэдорно” ХХК-ийн захирал Х.Бат-Эрдэнэ



**9. БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын  
нөхөн сэргээлтийн жилийн мэдээ**

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар  
зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

БОХ-3 маягт

**9. БОХ-1.3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн  
жилийн мэдээ**

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

**1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ**

Регистрийн дугаар	2	8	7	6	9	6	5
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	"Эрдэнэ Дорно" ХХК						
Байршил	Нэр						
Аймаг, нийслэл	Улаанбаатар хот						
Сум, дүүрэг	БГД 20-р хороо Өнөр хотхон 39-45						

1. Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт маягтаар ирүүлнэ.

2. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн газарт цахим хэлбэрээр ирүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 15-ны дотор Байгаль орчны мэдээллийн төвд цахим хэлбэрээр ирүүлнэ.

**2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	V	0	1	4	1	4	7
Тусгай зөвшөөрлийн талбай, га	228.81							
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	2	0	1	9	0	5	0	1
Ашигт малтмалын төрөл	Алт							
Ашиглалтын төрөл	Ил уурхай							

3. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээг хянаад 2 дугаар сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгжид цахим хэлбэрээр ирүүлнэ.

5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгж нь мэдээг хянаж, нэгтгээд 3 дугаар сарын 10-ны дотор статистик хариуцсан нэгжид цахимаар болон маягтаар ирүүлнэ.

6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик хариуцсан нэгж нь мэдээг хянаж, 3 дугаар сарын 20-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахимаар болон маягтаар ирүүлнэ.

**3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ**

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайлант онд (ашиглалт хийсэн)
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-	27.8	7.37
Ашигласан талбай	2	га	22.27	7.37
	3	мян.м <sup>3</sup>	211.52	70
Хаягдал чулуулгийн овоолго	4	га	2	0
	5	мян.м <sup>3</sup>	82	0
Хөрсний овоолго	6	га	0	0
	7	мян.м <sup>3</sup>	0	0
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар (отог)	8	га	1.92	1.92
Бусад (зам)	9	га	1	1

**4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ**

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техникийн		Биологийн	
				1	2	3	4
А	Б	В	1	2	3	4	
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га	19.3	19.3	19.3	19.3	
	11	мян.м <sup>3</sup>	212.3	183.3	29		
	Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	13.93	6.13	7.8	
	13	мян.м <sup>3</sup>	106.6	94.3	12.3		
Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай, мөр14≥мөр16, мөр15≥мөр17	14	га	21.4	13.94	15.26		
	15	мян.м <sup>3</sup>	177.4	153.3	24.1		
	Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	13.93	6.14	7.8	
	17	мян.м <sup>3</sup>	107.9	95.6	12.3		
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал, мөр18≥мөр19	18	мян.төг	93800	70350	23450		
	Тайлант онд нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал	19	мян.төг	26800	20100	6700	
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө, мөр20≥мөр21	20	мян.төг	54833.5	41125.125	13708.375		
	Тайланд онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	21	мян.төг	13934	x	x	
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал, мөр22≥мөр23	22	мян.төг	6000				
	Тайланд онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	23	мян.төг	1.8			

ТАМГА

Захирал/Эзэн .....

Х.Бат-Эрдэнэ/

Нягтлан бодогч .....

Э.Эрдэнэчимэг/

2022 оны 10 -р сарын 30 -ны өдөр

**10. Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл  
Тусгай зөвшөөрөл MV-14147-ийн нөөцийн дүгнэлт, тушаал**

Тайлан 5817



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2008 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

Баруун Уртын алтны шороон ордын  
Баруун дээд хэсгийн алтны нөөцийг  
хүлээн авч, бүртгэх тухай

“Ашигт малтмалын тухай” хуулийн 48 дугаар зүйлийн 4, ҮХЯ, АМГТХЭГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 19-02 дугаар дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсэгт явуулсан эрэл хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (ордын нөөц 2007 оны 12 – р сарын 30- ний байдлаар) дахь Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсгийн алтны бодитой (В) нөөцийг химийн цэврээр 51,12 кг, боломжтой (С) нөөцийг химийн цэврээр 8,52 кг, нийт бодитой болон боломжтой нөөцийг химийн цэврээр 59,64 кг-аар хүлээн авсугай;

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан алтны шороон ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв (Г. Алтанхуяг) – д зөвшөөрсүгэй;

3. Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсгийн алтны бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан, түүнийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзсүгэй;

4. ЭБМЗ-ийн 2008 оны 05 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 19-02 дугаар дүгнэлтийн 10-д заасан зүйлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулсныг зөвшөөрсүгэй;

5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, тайлангийн бичвэрийн диск, хээрийн судалгааны анхдагч материалын хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гарсан АМГТХЭГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг “Эрдэнэдорно” ХХК (Ч.Болд) - д даалгасугай.



Ж.БИЛЭГСАЙХАН

10 2005



**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ЯАМ**  
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**  
**ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

2008 оны 05 дугаар сарын  
28 -ны өдөр

Дугаар 19-2

Улаанбаатар  
хот

*Баруун Уртын алтны шороон ордын  
Баруун дээд хэсэгт гүйцэтгэсэн  
хайгуулын ажлын үр дүнгийн тайланг  
хэлэлцсэн тухай*

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсэгт 2005-2007 онд гүйцэтгэсэн алтны шороон ордын эрэл хайгуулын ажлын үр дүнгээр геологич Ц.Ганбат, Д.Туяа нарын зохиосон тайлан, уг тайлан дахь алтны шороон ордын нөөцийн тооцоонд геологич, проф Г. Ухнаагийн хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараахь ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна:

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Баруун Урт” нэртэй 229 га талбайд ашигт малтмалын хайгуул хийх 9104Х тоот тусгай зөвшөөрлийг анх АМГТХЭГ-ын ГУУКГ-аас “Ариун-Өрнөх” ХХК-д 2005 оны 01-р сарын 07-ны өдөр олгосон бөгөөд 2007 оны 11-р сарын АМГТХЭГ-ын КБГ-ийн даргын 2402 тоот шийдвэрээр “Эрдэнэдорно” ХХК-д шилжүүлсэн байна. “Ариун-Өрнөх” ХХК нь “Эрдэнэдорно” ХХК-тай хамтран энэ талбайд 2005-2007 онуудад эрэл хайгуулын ажил гүйцэтгэж Баруун Уртын алтны шороон ордын баруун дээд хэсгийн алтны бодитой (В) болон боломжтой (С) нөөцийг тогтоон, хайгуулын ажилд 11,1 сая төгрөг зарцуулжээ.

2. Тусгай зөвшөөрлийн талбай хамрагдаж буй энэ нутагт 1953 онд Ю.Б.Смирнов нар геологийн 1:50 000-ны масштабтай зураглалын ажил хийж томоохон ам хөндийнүүдэд цагаан тугалганы үйлдвэрлэлийн агуулгатай шороон ордын хуримтлал байж болох хэтийн төлөвтэй гээд эрлийн ажил явуулахыг зөвлөжээ. 1970-1980 онд Модотын геологийн экспедици Элст, Жанчивлангийн бүлэг шороон ордод хайгуулын ажлыг дуусгаж нөөцийг тооцсон байна. 1978-1980 онд Модотын экспедициэс Төв аймгийн хэд хэдэн сумын нутаг хамарсан эрлийн ажил хийсэн ба Г.И.Радченко, Д.Иваанжав нар Баруун уртын хэсэгт алтны шороон ордын эрэл үнэлгээний ажил хийж Баруун урт, Хошуу уул, Салхит зэрэг жижиг шороон ордууд илрүүлж эдгээр ордын нийт нөөцийг С<sub>2</sub>-Р<sub>1</sub> зэргээр 5,0 т гэж үнэлсэн байна. 1990 оноос Ч.Дашням, Л.Таазан, К.Шампан, Ч.Батаа нар дээрх ордуудад нарийвчилсан хайгуулын ажил, зэрэгцээ хөндийнүүдэд эрэл үнэлгээний ажил явуулжээ.

3. Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсэгт эрэл хайгуулын ажлыг ЭО-33-22 экскаватороор 3,5м хүртэл, түүнээс цааш гар аргаар, шурф малталтыг шугам хооронд 20 метр, шурф хооронд 20 метр зайтайгаар хайгуулын 7 шугмаар, 3,6 м дундаж гүнтэйгээр 54 шурф буюу 1963 тууш метр малталтын ажил хийж, 0,2-0,4м-ийн ахицаар 908 ширхэг сорьц авч угаалга хийн, эдгээрээс 586 ширхэг сорьцонд үлээлэг, жинлэлт хийх замаар гүйцэтгэсэн байна.



Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн шав тэмдэг болон ордын хэсгийн 1:2 000-ны масштабтай байрзүйн зургийн ажлыг ШУТИС-ийн геодезийн тэнхимийн багш А.Дамдинсүрэн, Ж.Алтанцэцэг нар “Leica” фермийн TC-800 маркийн электрон тахеометр, SET-3 цахилгаан теодолит ашиглан хийсэн бөгөөд энэ зурагт хайгуулын малталтуудын холболт хэмжилтийг хийж буулгажээ.

Ордын технологийн шинжилгээг хийгээгүй бөгөөд Баруун уртын ордод өмнөх судалгаагаар нарийвчлал сайтай, дэлгэрэнгүй хийсэн учраас энэ районд олборлолт хийж буй өөрийн болон бусад компаний олборлолтын үр дүнтэй харьцуулан алтны баяжигдах арга аргачлалыг шууд авч ашиглах боломжтой гэж үзсэн байна.

4. Баруун Уртын хөндийн дээд хэсгийн үүссэн алтны шороон орд нь хурдас хуримтлалын хувьд голын хөндийн татмын хэсгийн төрөлд, гарал үүслээрээ пролювиаль хурдсанд хамаарагддаг. Алт агуулагч хурдас нь цайвар саарал, саарал өнгөтэй, янз бүрийн мөлгөржилттэй, сортлогдож ангилагдаагүй хайрга, хайрганцар, янз бүрийн ширхэгтэй элс, хүрэн улаан өнгийн нягт шавар, шавранцараас тогтдог байна. Хурдаст 15 мм-ээс дээш хэмжээний занарын хэмхдэс 6,2-46,1%, 1-1,5 мм хэмжээний хэмхдэс 2,7-53,3%, элс 1,0мм-ээс бага нь 7-24%, шавар 2,3-52,7% байдаг байна. Алтны агуулга ордын хэмжээнд харьцангуй жигд, алтны шороон ордын давхарга нь нарийн урт, тууз маягийн хэлбэртэй, хөндийн өргөн нь дундажаар 50-60 м.

Баруун дээд хэсгийн алтны шороон орд нь 1,2 км урттай, 60 м өргөнтэй, бага гүнд оршдог, алтны тархалт нь жигд, давхаргын зузаан өөрчлөлт ихтэй учир III бүлгийн ордод хамааруулжээ.

5. Баруун Уртын хөндийн алтны шороон ордын Баруун дээд хэсгийн алтны нөөцийн тооцоонд хэрэглэсэн жишгийг сонгохдоо 1982-1983 онд хийсэн хайгуул, 1994, 1999-2000 онд Баруун уртын алтны шороон ордод хийсэн хайгуулын ажлын нөөцийн тооцоонд хэрэглэсэн жишиг үзүүлэлтийг авч хэрэглэсэн байна. Үүнд:

- нөөцийн блокын үйлдвэрлэлийн бага агуулга - 232 мг/м<sup>3</sup>,
- ашигт давхаргад орох захын агуулга -140 мг/м<sup>3</sup>,
- ашигт давхаргын хамгийн бага зузаан - 0.2 м,
- ашигт давхаргын хамгийн бага өргөн-20м,
- блок доторх жишгийн бус агуулгатай хэсгийн өргөн-20м,

Алтны сорьц дундажаар 876.

6. Баруун Уртын хөндийн алтны шороон ордын Баруун дээд хэсэгт 2005-2007 онд хийсэн хайгуулын ажлаар бодитой (В) зэргээр 6 блокт алтны нөөцийг химийн цэврээр 52,9 кг-аар, боломжтой (С) зэргээр 2 блокт алтны нөөцийг химийн цэврээр 8,52 кг –аар, нийт бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 61,4 кг-аар тогтоосон ба алтны дундаж агуулгыг 376 мг/м<sup>3</sup>, хуулах хөрсний дундаж зузааныг 1,76 м, алт агуулсан элсний дундаж зузааныг 1,03 м-ээр тогтоожээ. Хайгуулын явцад гоц өндөр агуулга тогтоогдоогүй байна.

Шинжээч дээрхи нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж, алтны бодитой (В) нөөцийг химийн цэврээр 51,12 кг, боломжтой (С) нөөцийг химийн цэврээр 8,52 кг, нийт бодитой болон боломжтой нөөцийг химийн цэврээр 59,64 кг-аар хүлээн авахыг санал



болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар алтны шороон ордын нөөцийг шинжээчийн тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзэв.

7. Ширхэглэлийн бүтэц, эрдсийн шинжилгээний үр дүнгээс харахад алт нь хавтгайвтар, бөөрөнхий хэлбэртэй,  $-0,125+0,63$  мм-ийн алт нь 0,02%,  $-0,25+0,125$  мм-ийн алт нь 2,87%,  $-0,5+0,25$  мм-ийн алт нь 41,69%,  $-1,0+0,5$  мм-ийн алт нь 39,11%,  $-0,2+1,0$  мм-ийн алт 16,31%, ба 0,25 мм-ээс бага мөхлөгтэй алтны тархалт 8% орчим. Алтны олборлолтын ажлыг тухайн районд олборлолт явуулж байгаа үр дүнгээс харахад шаталсан ангиллаар шигшин угааж шлозны технологиор баяжуулахад металл авалт 95% -тай байдаг бөгөөд энэ ордод хэрэглэх бүрэн боломжтой гэж үзжээ.

8. Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсгийн талбай нь багавтар хэмжээний цэвдэгтэй, ордын хэмжээнд элс, элсэнцэр бага, голлон шавранцартай, алт агуулагч үе нь зарим хэсэгтээ сэвсгэр хурдасны уст давхаргын дээд хэсэгт байрладаг байна. Ашигт давхарга нь алюви-пролювийн гаралтай хайрга хайрганцар, элсэрхэг хурдсаас бүрдэх ба сийрэгжилтийн итгэлцүүр ордын хэмжээнд 1,4. Хөндийд түр зуурын урсгал устай жижиг булагтай, хөрсний усны түвшин газрын гадаргаас их биш 2-3 м хааяа 5-12м, ус нь цэнгэг. Хөндийд өмнөх өрөмдлөгийн ажлаар уст цэг тогтоогдсон байх ба энэ нь 1.2-5л\сек ундратай, шурф малталтаар боржингийн өгөршлийн хэсэгт 0.3-0.5л\сек ундратай ус илэрдэг байна. Ордыг олборлоход гадаргуугийн усаар хангах боломжгүй учир гүний усыг ашиглана гэж төлөвлөсөн байна.

9. Тусгай зөвшөөрлийн талбайд тогтоогдсон алтны шороон ордын нөөцийн тооцоог үндэслэн ТЭЗ-ийн урьдчилсан тооцоо хийсэн бөгөөд үүгээр өнөөгийн ашиглалт, үйлдвэрлэлийн техник тоног төхөөрөмжийн түвшинд 6 жилийн хугацаатай олборлож дуусгахаар төлөвлөсөн ба ордоос нийт 285,5 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 248.5 мян.м<sup>3</sup> элс угааж, түүнээс ашиглалтын хаягдлыг 3%, технологийн хаягдал 8% -иар тооцсоноор нийт 55.78 кг алт олборлож, борлуулснаар борлуулалтын орлого 1673.7 сая төгрөг, ашиглалтын зардал 1355.0 сая төгрөг, цэвэр ашиг 17.1 сая төгрөг байхаар тооцсон байна.

10. Ордын гидрогеологийн судалгааг хийж үйлдвэрлэлийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, ашиглалтын үед байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг ТЭЗҮ болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд бодит байдлаар тусгах, орд газрыг ашиглах явцад ашиглалтын хайгуул хийх замаар эрсдэлээ аль болохоор багасгаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоо хийсэн шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн, ҮХЯ, АМГТХЭГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах төслийн дагуу шийдвэр гаргахыг АМГТХЭГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв:

1. “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсэгт явуулсан эрэл хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (ордын нөөц 2007 оны 12 – р сарын 30- ний байдлаар) дахь Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсгийн алтны бодитой (В) нөөцийг химийн цэврээр 51,12 кг, боломжтой (С) нөөцийг химийн цэврээр 8,52 кг, нийт бодитой болон боломжтой нөөцийг химийн цэврээр 59,64 кг-аар хүлээн авах;

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан алтны шороон ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв (Г. Алтанхуяг) – д зөвшөөрөх;


3. Баруун Уртын алтны шороон ордын Баруун дээд хэсгийн алтны бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан, түүнийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзэх;

4. Энэхүү дүгнэлтийн 10-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэдорно” ХХК (Ч.Болд) - д анхааруулах;

5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, тайлангийн бичвэрийн диск, хээрийн судалгааны анхдагч материалын хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гарсан АМГТХЭГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг “Эрдэнэдорно” ХХК (Ч.Болд) - д даалгах.

ТАНИЛЦСАН:


ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ДЭД САЙД,  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.СОДБААТАР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

АМГТХЭГ-ЫН ДЭД ДАРГА,  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
АХЛАГЧ




М.АРИУНБАЯР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН





ЭБМЗ-ийн 2008 оны 05 дугаар сарын 28 - ны  
одрийн 19 дугаар хуралдааны 19-2 дугаар  
дүгнэлтийн хавсралт

Баруун Уртын алтны шороон ордын  
Баруун дээд хэсгийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Блоктын дугаар	Шугамын дугаар	Шурфын тоо	Дундаж зузаан метр		Дундаж агуулга мг/м.куб	Нөөцийн блоктын талбай метр. кв	Эзлэхүүн мян. м.куб		Алтны нөөц кг		Хөрс хуулагтын коэффициент
			хучаас	элс			Хучаас	Элс	шлихийн	химийн цэвэр	
2-В	74-76	5	1.68	0.96	571	22386.00	39,17	22,38	12.78	11.20	1.75
3-В	79-76 <sup>А</sup>	5	1.80	1.00	506	22750.00	40,95	22,75	11.51	10.08	1.80
4-В	76 <sup>А</sup> -78	5	1.88	1.08	292,4	21500.00	40,42	23,22	6.78	5.95	1.74
5-В	78-80	8	1.51	1.00	227,0	37600.00	56,78	37,60	10.60	7,48	1.30
6-В	80-82	7	1.67	1.26	252	28687.50	47,91	36,15	9.10	7.98	1.30
7-В	82-84	7	1.77	0.83	387	29962.50	53,03	24,87	9.62	8.43	2.10
Бүгд-В нөөц			1.70	1.05	376	162886.00	278,26	166,97	60.39	51.12	1.66
1-С	74	8	2.20	1.00	479	9243.75	20,33	9,24	4.43	3.88	2.00
8-С	84	5	1.84	0.60	485	18218.75	33,52	10,93	5.30	4.64	3.00
Бүгд-С нөөц			1.96	0.73	482	27462.50	53,85	20,17	9.73	8.52	2.50
Нийт В+С нөөц						190348.50	330273.10	309786.00	70.12	59,64	

## Тусгай зөвшөөрөл MV-12125, MV-14147 дахь ТЭЗҮ-ийн дүгнэлт



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 1/65

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл  
хүлээн авах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны т/17-07-01 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших "Эрдэнэдорно" ХХК-ийн MV-012125, MV-014147 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-012125, MV-014147 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг "Эрдэнэдорно" ХХК /Х.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

  
Б.БААТАРЦОГТ

10 0939

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

2017 оны 07 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар т/17-07-01

Улаанбаатар хот

*Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-012125, MV-014147 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хэлэлцсэн тухай*

“Эрдэнэдорно” ХХК-ийн захиалгаар уул уурхайн зураг төслийн “Майндата” ХХК-ийн инженерүүдийн боловсруулсан Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-д Монгол улсын зөвлөх инженер Д.Болор зөвлөн, Монгол улсын зөвлөх инженер Д.Бадамдорж шинжээч дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/ нь Оршил, Ордын талбайн ерөнхий мэдээлэл, Геологийн судалгаа, Нөөцийн тооцоо, Ил уурхай, Баяжуулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Хүний нөөц, Эдийн засаг болон Дүгнэлт зэрэг 12 бүлэг, 102 хуудас тайлбар бичиг, 49 хуудас хавсралт материал, 12 ш хавсралт зургуудаас бүрдэж байна. ТЭЗҮ-г ил уурхайн төлөвлөлт, ил уурхайн ашиглалтын болон баяжуулалтын технологи, машин техник, тоног төхөөрөмжийн сонголтын тооцоо, дэд бүтэц, нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, төслийн эдийн засаг гэсэн хэсгүүдээс бүрдсэн байна.
2. Ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 13-07 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2009 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 336 дугаар тушаалаар Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун урт нэртэй MV-012125 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах алтны бодитой (В) нөөцийг 125.92 кг, боломжтой (С) нөөцийг 5.02 кг алт, нийт бодитой болон боломжтой (В+С) /химийн цэврээр/ 130.94 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Үүнээс хойш олборлолтын ажил явагдаж 2017 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар нийт бодитой болон боломжтой (В+С) /химийн цэврээр/ 40.79 кг алтны нөөцийн үлдэгдэлтэй байна.
3. Ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 19-2 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2008 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 267 дугаар тушаалаар Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Баруун уртын баруун дээд хэсэг



нэртэй MV-014147 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах алтны бодитой (В) нөөцийг 51.12 кг, боломжтой (С) нөөцийг 8.52 кг алт, нийт бодитой болон боломжтой (В+С) /химийн цэврээр/ 59.64 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордын ашиглалтын нөөцийг нийт бодитой болон боломжтой (В+С) /химийн цэврээр/ 100.43 кг алтны нөөцөөр ТЭЗҮ-д ашиглахаар тусгасан байна.

4. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо Баруун уртын ордын үлдэгдэл нөөц болон Баруун уртын баруун дээд хэсгийн батлагдсан (В+С) нөөцийг магадласан В' зэрэгт шилжүүлж ашиглалтын үеийн бохирдолт 12.95%-19.2%, тээвэрлэлтийн хаягдал 2%-р тус тус авч тооцон нийт 3 жилийн хугацаанд уулын ажил явуулж, нийт 388.9 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 350.4 мян.м<sup>3</sup> элс олборлож, В' зэргээр /химийн цэврээр/ 98.2 кг алтны нөөцийг олборлохоор тооцсон байна. Уурхайн жилийн хүчин чадал 110.8 мян.м<sup>3</sup> элс байхаар тусгажээ.
5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг ордын геологийн тогтцод үндэслэн автотээвэртэй, гадаад болон дотоод овоолготой ашиглалтын систем хэрэглэхээр төсөлд тусгасан байна.
6. Уулын ажилд 1.5 м<sup>3</sup> шанагатай Doosan DX300 маркийн экскаватор 1 ш, 0.8 м<sup>3</sup> шанагатай Doosan DX300 маркийн экскаватор 1 ш, тээвэрт 15 тн даацтай Hyundai HD маркийн автосамосвал 3 ш, хөрсний овоолгод 3 м<sup>3</sup> утгуурын багтаамж бүхий Doosan маркийн утгуурт ачигч 1 ш зэрэг ажиллах ба эдгээр нь хоорондоо бүтээлээрээ нягт уялдсан, хөрөнгө оруулалт болон ашиглалтад хамгийн бага зардал гаргах нөхцөлийг хангахаар төсөлд тусгагдсан байна.
7. Баяжуулалтын технологийн металл авалтыг 92%-аар, нийт 3 жилийн хугацаанд 350.4 мян.м<sup>3</sup> элс боловсруулж, химийн цэврээр 90.34 кг алт үйлдвэрлэхээр тооцсон байна.
8. Ашиглалтын явцад эвдэгдсэн газрын нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5917:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг стандартуудын дагуу гүйцэтгэж, эвдэгдсэн газрыг налуулж хэлбэршүүлэн хүн, мал, амьтан явахад аюулгүй болгох, үржил шимт давхаргыг нөхөн сэргээх, тус нутгийн уур амьсгалд тохирсон ургамал тарьж орчныг ургамалжуулах зэрэг ажлуудыг хийх бөгөөд байгаль орчин хамгаалал, нөхөн сэргээх зардалд 3 жилийн хугацаанд 325.0 сая төгрөг тусгасан байна.
9. Төсөл хэрэгжүүлэхийн тулд нийт 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Төслийн нийт хугацаанд борлуулалтын нийт орлого 8.9 тэрбум төгрөг, ашиглалтын зардал 5.5 тэрбум төгрөг, цэвэр ашиг 3.1 тэрбум төгрөг байна. 1 грамм алтны бүрэн өөрийн өртөг дунджаар 66,366 төгрөг байна. Улс, орон нутгийн төсөвт 1.5 тэрбум төгрөгийн орлогыг татвар, төлбөрийн хэлбэрээр оруулахаар байна. Сум, орон нутгийн хөгжилд зориулан төсөл хэрэгжих хугацаанд нийт 150.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.



10. Төслийн өнөөгийн цэвэр ашиг (NPV, 10%) 2,279 сая төгрөг байх ба өгөөжийн дотоод норм (IRR) 81.7%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 11.2 сар байхаар тооцжээ.
11. Төсөл хэрэгжсэнээр 44 ажлын байр бий болох ба ажилчдын сарын цалин 1.0-1.5 сая төгрөг байхаар төсөлд тусгасан байна.
12. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
13. Техник-эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн төвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
14. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчдийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараах шийдвэрүүдийг гаргах тухай Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар шийдвэрлэв.

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-012125, MV-014147 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.
2. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон комисс уурхайг хүлээн авсны дараа уг уурхайг энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу ажиллуулж эхлэхийг “Эрдэнэдорно” ХХК /Х.Бат-Эрдэнэ/-д анхааруулах.
3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу жил бүр уулын ажлын төлөвлөгөөг боловсруулж зохих газраар хянуулах, холбогдох бусад зөвшөөрлийг эрх бүхий бусад хуулийн этгээдээс авахыг “Эрдэнэдорно” ХХК /Х.Бат-Эрдэнэ/-д, уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгохыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс /Д.Хангай/-т тус тус даалгах.
4. ЭБМЗ-ийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн энэхүү хуралдааны т/17-07-01 дүгээр дүгнэлтийн 8,9,12-д заасныг хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэдорно” ХХК /Х.Бат-Эрдэнэ/-д анхааруулж, төлөвлөгөөний


хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс /Д.Хангай/-т даалгах.

5. ЭБМЗ-ийн дүгнэлт, АМГТГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан техник-эдийн засгийн үндэслэлийн бичвэрийг цаасаар болон, дискээр Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг “Эрдэнэдорно” ХХК (Х.Бат-Эрдэнэ)-д даалгах.
6. Шийдвэрийн 5-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авахыг “Эрдэнэдорно” ХХК /Х.Бат-Эрдэнэ/-д анхааруулах.
7. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан ил уурхайн хүчин чадал, технологийн шат, дамжлагыг өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд нэмэлт өөрчлөлт оруулахыг “Эрдэнэдорно” ХХК /Х.Бат-Эрдэнэ/-д, Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс /Д.Хангай/-т тус тус даалгах.
8. “Эрдэнэдорно” ХХК-ийн захиалгаар Баруун урт болон Баруун уртын баруун дээд хэсгийн алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, баяжуулах технологи, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчин, нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан уул уурхайн зураг төслийн “Майндата” ХХК хариуцах бөгөөд түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Д.Бадамдорж хариуцна.


ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Б.БААТАРЦОГТ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ХУРАЛДААНЫ ДАРГА  Ж.ГАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Д.МААСҮРЭН

**11. БОМТ-ний биелэлтийн тайлан хүлээн авах хяналтын хуудас**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн  
А/618 тоот тушаалын хавсралт Журмын 6 дугаар хавсралт  
Хүснэгт №1

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтний хувийн дугаар	
Дүгнэлт	
Шийдвэрийн төсөл	
Ололт, амжилттай тал	
Дутагдалтай сул тал	
Шаардлага	

Хоёр. Төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олгодог тугай зөвшөөрөл, дүгнэлт, лавлагааны  
товч мэдээлэл

хүснэгт №2

д/д	Мэдээллийн төрөл	Утга	
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ дугаар хүчинтэй хугацаа талбай	Ашигт малтмал ашиглах MV-012125, 014147 30 жил 195.4 га, 225 га	
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ дугаар хүчинтэй хугацаа	хамаарахгүй	
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	хамаарахгүй	
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	-	
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2018-01-16 2018/Т-012 БОАЖЯ-ны шинжээч Д.Тэмүүлэн	
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2018 БОАЖЯ-ны ерөнхий шинжээч Г.Нямдаваа	
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2022	
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2022	
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах		
	10.Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/  Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/	тайлант онд гүйцэтгэсэн
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх
		6.14	
		6.13	
		7.8	
		7.8	
11. ТХГН-ийн тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах		Лавлагаа гаргуусан	

Мэдээллийг гаргасан: *С.Ганбат* Уул уурхайн инженер. /С.Ганбат/

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

хүснэгт №3

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	1. Тосгон	+
	2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт)	+
	3. Хог хаягдлын цэгийн байршил	+
	4. Хог хаягдлын агуулахын байршил	Хамааралгүй
	5. Хог хаягдлын далан	
	6. Химийн бодисын агуулахын байршил	+
	7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил	+
	8. Тухайн жилд хуулах хөрс	+
	9. Гадаад, дотоод овоолго	+
	10. Техникийн нөхөн сэргээлтийн талбай	+
	11. Биологийн нөхөн сэргээлтийн талбай	+
	12. Гүний худгийн байршил	
13. Дүйцүүлэн хамгааллын байршил		

Мэдээллийг гаргасан: .....

2022 он ..... сар..... өдөр



Зургаа. Тухайн жилийн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээний хяналтын хуудас

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь баганад “тодорхойлсон (+)”, “тодорхойлоогүй (-)” “хамааралгүй (=)” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

хүснэгт №4

Нөлөөллийн ангилал	А.	Б.	В.	Г.	Дүгнэлт
	Тооцсон эсэх	Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	+ + +	+ + +	+ + +	+ + +	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	+ +	+ +	+ +	+ +	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах	+ + + +	+ + + +	+ + + +	+ + + +	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	+ +	+ +	+ +	+ +	

Тайлбар: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэгээний тайлангаас авав.

Мэдээллийг гаргасан: *С.Ганбат* Уул уурхайн инженер. /*С.Ганбат*/

Долоо. Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт  
 - Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх  
 - Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.

хүснэгт №37

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А.	Б.	В.	Г.
	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Дүгнэлт
7.1.Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ		тийм	тийм	
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
7.3.Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн / га, - м <sup>3</sup> / - биологийн /га/	15.5 га	тийм	тийм	
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	-	тийм	тийм	
7.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	1	тийм	тийм	
7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ		үгүй	үгүй	
7.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ		тийм	тийм	

Мэдээллийг гаргасан: *С.Ганбат* Уул уурхайн инженер. /*С.Ганбат*/

## 12. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар

Энэ асуудлын хүрээнд гэрээг даатгалын компани дээр судалж хийх гэж байна.

## 13. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар

Жилийн эцсийн тайлангаар гарна.

## 14. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар

Жилийн эцсийн тайлангаар гарна.

**15. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ**  
Манай компани экспортод бүтээгдэхүүн гаргадаггүй.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

2022 оны 5-р сарын 4-ны өдөр

Гаалийн Ерөнхий газрын даргын 2019 оны  
А/... дугаар тушаалын ...-р хавсралт

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
**ГААЛИЙН МЭДҮҮЛГЭЭР БҮРДҮҮЛЭЛТ ХИЙСЭН БАРААНЫ  
ЛАВЛАГАА (ААН)**

ААН	Эрдэнэдорно ХХК
Регистрийн дугаар	2876965
Хаяг байршил	Улаанбаатар, Баянгол, өнөр хотхон, null
Лавлагаанд хамаарагдах огноо	2021-01-01 / 2021-12-31
Төрөл	Экспорт
Гаалийн бүрдүүлэлт хийсэн тоо	0
Үнийн дүн /ам.дол/	0.00
Үнийн дүн /төгрөг/	0.00
Гаалийн татвар /төгрөг/	0.00
Онцгой албан татвар /төгрөг/	0.00
Албан татвар /төгрөг/	0.00
НӨАТ /төгрөг/	0.00
Бусад татвар, хураамж /төгрөг/	0.00
Горимын код	-

UANKBS1U-  
NHNS-4HVB

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа: 2022/06/18 (45 хоног)

Энэхүү тодорхойлолт дах мэдээллийн үнэн зөв эсэхийг <https://gaali.mn/>  
холбоосоор эрх бүхий этгээд нэвтрэн орж шалгах боломжтой.



16. “Баруун урт”, “Баруун уртын баруун дээд” алтны ил уурхайн 2021 оны үйл ажиллагаа, БО-ны нөхөн сэргээлтийн тайлан Хавсралт зураг №1 масштаб 1:2000  
Хавсралт зургийг хавсаргав.

17. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар

УБ-2	Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.	
	<b>МОНГОЛ УЛС</b> <b>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</b>	
0000110850	9011071137	
2006.02.24	/ Бүртгэсэн он, сар, өдөр /	
	/ Улсын бүртгэлийн дугаар /	
	2876965	
	/ Регистрийн дугаар /	
Эрдэнэдорно	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /		
Дүрэм		
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /		
Шийдвэр	01	2005.03.09
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /
4610	Гаднаад худалдаа	
/ код /	/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /	
0710	Ашигт малтмал ашиглах /2009.09.11-2038.09.11/	
/ код /	/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /	
Хугацаагүй	1	54,000.00
/ хугацаа /	/ илшүүдийн тоо /	/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /
Улаанбаатар, Баянгол, 4-р хороо, Энэр хотхон, 05-19/1, /тас1: 99111230, Утас2: , Факс:		
/ хуулийн этгээдийн байрны нэр /		
		
Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар		
/ бүртгэсэн байгууллагын нэр /		
Гэрчилгээ дахин олгосон 2015 он 11 сар 24 өдөр		

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Хорлоо овогтой Батэрдэнэ-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2015.11.24	Ж.Нямдорж
2	Дахин гэрчилгээ олгов.	2015.11.24	Ж.Нямдорж
1	Хувь нийлүүлэгчээс 2 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2016.03.23	Г.Алтай

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариушлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

